



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 24 өдөр

Дугаар А/367

Есөнбулаг сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам"-ын 3 дугаар 3.5.4 дахь хэсэг, Тагнуулын ерөнхий газрын ТЕГ01/391 дүгээр албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн болон албаны нууцад хамаарах баримт, бичгийг нягтлан шалгаж хууль тогтоомжид нийцүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2.Төрийн нууцад хамаарах болон тагнуулын байгууллагаас зөвлөсөн нийтлэг жишгээс бусад хуулийн шалгуур хангахгүй үндэслэлээр хүчин төгөлдөр мөрдөгдөж жагсаалтаас хасагдаж буй нууцын дардас тэмдэглэгээ дарж бэхжүүлсэн баримт бичгийг, Төрийн нууцад хамаарах мэдээллийг зэрэглэл бууруулж албаны нууцад хамаарах мэдээллийг, хүний хувийн мэдээллийг тус тус албаны нууцын жагсаалтад баталсан бол түүнээс хасах, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам"-ын дагуу албаны нууцад хамаарах баримт бичгийг нэг бүрчлэн нягтлан шалгаж нууцлах хугацааг сунгах, ил болгох, ажлыг хууль журмын хүрээнд нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир)-д, Сумдын Засаг дарга нар, Тамгын газрын дарга, нууц хамгаалах ажилтнуудад тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир)-д даалгасугай.

4.Тухайн ажлын нууцлал, аюулгүй байдлыг хангаж тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир)-д, Сумдын Засаг дарга нар, Тамгын газрын дарга, нууц хамгаалах ажилтнуудад тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 24-ны өдрийн 267 дүгээр
захирамжийн хавсралт

АЙМАГ, СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТЫГ
НЯГТЛАН ШАЛГАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн, байгууллагын нууц хамгаалах ажилтан
Гишүүн:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн Сумын Засаг дарга, Тамгын газрын дарга нар буюу нууц хамгаалах ажилтнууд